ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/60/СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитын менежер:Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Д.Мягмарсүрэн
Утас: 99030170 Цахим хаяг: www.dalaivanaudit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....9
3.Аудитын тайлан ....10
3.1. Ерөнхий зүйл ....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....11
3.4. Материаллаг байдал ....11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....13
3.7. Шилэн дансны мэдээлэл ....13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....13
3.9. Аудитын илрүүлэлт ....14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....14

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Хандоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 47

танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН ОЮУ
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.БОЛОРМАА ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,711,706.69** | **89,831,625.09** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 97,623,467.09 | 89,831,625.09 |
| **351** | **Түүхий эд материал** | 90,239,497.09 | 87,474,705.09 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 90,239,497.09 | 85,453,445.09 |
| 35130 | Эм боох материал | - | 2,021,260.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,383,970.00 | 2,356,920.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 1,375,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 167,400.00 | 800.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,022,270.00 | 980,320.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,300,361,132.38** | **2,246,822,591.01** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,300,361,132.38 | 2,246,822,591.01 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,108,148,632.34 | 2,054,747,590.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,077,719,594.24 | 2,077,719,594.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (46,017,607.23) | (92,043,964.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,375,325.00 | 63,231,725.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (35,795,549.56) | (40,588,108.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 114,385,257.40 | 114,385,257.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (56,518,387.51) | (67,956,913.15) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 192,212,500.04 | 192,075,000.08 |
| 39301 | Програм хангамж | 1,230,000.00 | 1,230,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (817,499.96) | (954,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 191,800,000.00 | 191,800,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,399,072,839.07** | **2,336,654,216.10** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,398,865,740.07** | **2,336,654,216.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,398,865,740.07 | 2,336,654,216.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 191,800,000.00 | 191,800,000.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 191,800,000.00 | 191,800,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 468,511,830.31 | 406,300,306.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 468,511,830.31 | 468,511,830.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (62,211,523.97) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,738,553,909.76 | 1,738,553,909.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,399,072,839.07** | **2,336,654,216.10** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **643,374,325.00** | **613,893,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,111,825.00** | **17,129,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 51,111,825.00 | 17,129,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 51,111,825.00 | 17,129,800.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 51,111,825.00 | 17,129,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **592,262,500.00** | **596,763,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 497,248,300.00 | 555,244,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 497,248,300.00 | 555,244,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35,528,800.00 | 41,519,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35,528,800.00 | 41,519,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **656,700,499.51** | **676,104,823.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **656,700,499.51** | **676,104,823.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 656,476,778.29 | 662,210,967.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 399,551,781.00 | 441,258,299.73 |
| 210101 | Үндсэн цалин | 331,155,096.00 | 311,523,935.14 |
| 210102 | Нэмэгдэл | 43,492,591.00 | 97,077,538.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,060,000.00 | 15,726,141.00 |
| 210104 | Урамшуулал | 20,844,094.00 | 16,930,685.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,184,080.38 | 57,548,479.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,798,780.38 | 39,951,979.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,596,300.00 | 4,399,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,877,000.00 | 3,519,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 719,300.00 | 879,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,192,700.00 | 8,798,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,427,311.78 | 31,160,050.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,581,235.26 | 2,726,341.90 |
| 210302 | Түлш, халаалт | 22,907,516.52 | 22,050,643.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,938,560.00 | 6,383,065.61 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,383,518.00 | 25,346,656.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,283,955.00 | 193,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 470,674.00 | 155,924.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 123,200.00 | 4,391,980.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,244,600.00 | 12,698,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,261,089.00 | 7,906,452.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 88,915,590.00 | 39,518,440.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 125,200.00 | 55,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 88,790,390.00 | 39,429,740.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 33,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,391,700.00 | 1,863,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,391,700.00 | 1,863,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 628,000.00 | 1,030,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 628,000.00 | 1,030,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,914,797.13 | 64,486,041.37 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 794,050.00 | 2,091,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 56,975,397.13 | 62,394,941.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 223,721.22 | 13,893,856.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 150,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 222,788.22 | 72,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 222,788.22 | 72,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 933.00 | 13,671,856.81 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 933.00 | 13,671,856.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(13,326,174.51)** | **(62,211,523.97)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(23,528,001.51)** | **(62,211,523.97)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **605,494,153.69** | **600,345,491.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **605,494,153.69** | **600,345,491.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 498,358,244.69 | 555,244,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 497,248,300.00 | 555,244,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,485,400.00 | 72,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | 72,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35,528,800.00 | 41,519,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35,528,800.00 | 41,519,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 12,121,709.00 | 3,509,991.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 12,121,709.00 | 3,509,991.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **604,944,153.69** | **600,345,491.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **604,944,153.69** | **600,345,491.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **592,526,578.78** | **582,941,643.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,655,883.00 | 440,449,159.13 |
| 210101 | Үндсэн цалин | 335,259,198.00 | 311,523,934.54 |
| 210102 | Нэмэгдэл | 43,492,591.00 | 97,077,538.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,060,000.00 | 15,726,141.00 |
| 210104 | Урамшуулал | 20,844,094.00 | 16,121,545.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,803,200.00 | 57,548,479.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,417,900.00 | 39,951,979.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,596,300.00 | 4,399,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,877,000.00 | 3,519,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 719,300.00 | 879,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,192,700.00 | 8,798,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,427,311.78 | 31,160,050.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,581,235.26 | 2,726,341.90 |
| 210302 | Түлш, халаалт | 22,907,516.52 | 22,050,643.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,938,560.00 | 6,383,065.61 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,840,674.00 | 6,827,764.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 877,900.00 | 193,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 470,674.00 | 155,924.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 123,200.00 | 6,130,240.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 368,900.00 | 348,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 95,518,260.00 | 40,661,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 55,600.00 | 206,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 89,812,660.00 | 39,387,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,650,000.00 | 1,067,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,941,700.00 | 1,864,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,941,700.00 | 1,864,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 628,000.00 | 1,030,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 628,000.00 | 1,030,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,631,550.00 | 3,400,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,486,200.00 | 3,400,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,417,574.91** | **17,403,847.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,121,709.00 | 3,659,991.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 12,121,709.00 | 3,509,991.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 150,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 222,788.22 | 8,567,449.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 222,788.22 | 8,567,449.33 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 933.00 | 5,176,407.48 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 933.00 | 5,176,407.48 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 191,800,000.00 | 1,738,553,909.76 | 484,778,887.51 | 2,415,132,797.27 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **191,800,000.00** | **1,738,553,909.76** | **484,778,887.51** | 2,415,132,797.27 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (16,267,057.20) | (16,267,057.20) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **191,800,000.00** | **1,738,553,909.76** | **468,511,830.31** | 2,398,865,740.07 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **191,800,000.00** | **1,738,553,909.76** | **468,511,830.31** | 2,398,865,740.07 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **191,800,000.00** | **1,738,553,909.76** | **468,511,830.31** | 2,398,865,740.07 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (62,211,523.97) | (62,211,523.97) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **191,800,000.00** | **1,738,553,909.76** | **406,300,306.34** | 2,336,654,216.10 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх оны | Тайлант оны | |
|---|---|---|---|---|
| | | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 605,198,287.78 | 596,763,500.00 | 583,091,643.19 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 604,648,287.78 | 596,763,500.00 | 583,091,643.19 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 592,526,578.78 | 596,613,500.00 | 582,941,643.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,655,883.00 | 440,449,200.00 | 440,449,159.13 |
| 210101 | Үндсэн цалин | 335,259,198.00 | 291,665,200.00 | 311,523,934.54 |
| 210102 | Нэмэгдэл | 43,492,591.00 | 109,197,300.00 | 97,077,538.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,060,000.00 | 3,360,000.00 | 15,726,141.00 |
| 210104 | Урамшуулал | 20,844,094.00 | 36,226,700.00 | 16,121,545.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,803,200.00 | 57,548,700.00 | 57,548,479.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,417,900.00 | 39,952,200.00 | 39,951,979.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,596,300.00 | 4,399,100.00 | 4,399,100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2102 03 | ҮОМШӨ-ний даатгал | 2,877,000.00 | 3,519,300.00 | 3,519,300.00 |
| 2102 04 | Ажилгүйдлийн даатгал | 719,300.00 | 879,800.00 | 879,800.00 |
| 2102 05 | Эрүүл мэндийн даатгал | 7,192,700.00 | 8,798,300.00 | 8,798,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,427,311.78 | 39,235,300.00 | 31,160,050.67 |
| 2103 01 | Гэрэл, цахилгаан | 5,581,235.26 | 8,144,600.00 | 2,726,341.90 |
| 2103 02 | Түлш, халаалт | 22,907,516.52 | 25,929,600.00 | 22,050,643.16 |
| 2103 03 | Цэвэр, бохир ус | 4,938,560.00 | 5,161,100.00 | 6,383,065.61 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,840,674.00 | 10,847,100.00 | 6,827,764.00 |
| 2104 01 | Бичиг хэрэг | 877,900.00 | 193,400.00 | 193,400.00 |
| 2104 03 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 470,674.00 | 156,700.00 | 155,924.00 |
| 2104 05 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 123,200.00 | 10,027,800.00 | 6,130,240.00 |
| 2104 06 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 368,900.00 | 348,200.00 | 348,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 95,518,260.00 | 40,661,600.00 | 40,661,490.00 |
| 2105 01 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 55,600.00 | 206,200.00 | 206,200.00 |
| 2105 02 | Хоол, хүнс | 89,812,660.00 | 39,387,800.00 | 39,387,790.00 |
| 2105 03 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,650,000.00 | 1,067,600.00 | 1,067,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,941,700.00 | 2,284,200.00 | 1,864,000.00 |
| 2106 04 | Урсгал засвар | 1,941,700.00 | 2,284,200.00 | 1,864,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 628,000.00 | 1,376,200.00 | 1,030,000.00 |
| 2108 02 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 628,000.00 | 1,376,200.00 | 1,030,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,631,550.00 | 4,013,500.00 | 3,400,700.00 |
| 2109 02 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,486,200.00 | 3,400,700.00 | 3,400,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,121,709.00 | 150,000.00 | 150,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,121,709.00 | 150,000.00 | 150,000.00 |
| 2132 09 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 150,000.00 | 150,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 544,898,809.00 | 596,763,500.00 | 596,763,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 497,248,300.00 | 555,244,000.00 | 555,244,000.00 |
| 1310 07 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 497,248,300.00 | 555,244,000.00 | 555,244,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 35,528,800.00 | 41,519,500.00 | 41,519,500.00 |
| 1320 01 | Орон нутгийн төсвөөс | 35,528,800.00 | 41,519,500.00 | 41,519,500.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Оюу цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын эрхлэгч Г.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 05-наас 2021 оны 02 дугаар сарын 08–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь “Бүтээлч сэтгэлгээтэй зөв монгол хүүхдийг төлөвшүүлж, хэзээд манлайлагч байна” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн байгууллагын дотоод хяналтын комисс нь 2020 онд Боловсрол, Эрүүл ахуй халдвар хамгаалал, Хүнсний аюулгүй байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Санхүү өмчийн бүртгэл тооцоо гэсэн 5 чиглэлээр хяналт шалгалт явуулж, алдаа зөрчил гаргасан ажилчдад сануулга өгч, засч залруулах үүрэг даалгавар өгөн ажилласан байна.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 350,468.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,504.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 613,893.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,138.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62,418.6 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 1,088.2 | 0 | (1,088.2) |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 97,623.4 | 89,831.6 | (7,791.8) |
| Үндсэн хөрөнгө | 2,300,361.1 | 2,246,822.6 | (53,538.5) |
| **Нийт хөрөнгө** | **2,399,072.8** | **2,336,654.2** | **(62,418.6)** |
| Өр төлбөр | 207.1 | 0 | (207.1) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,398,865.7 | 2,336,654.2 | (62,211.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,399,072.8** | **2,336,654.2** | **(62,418.6)** |

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 1,088.2 мянган төгрөг байсан ба тайлант онд 3,309.9 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, бүх авлагыг бүрэн цуглуулж авлагын үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 89,831.6 мянган төгрөг болж 7,791.8 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд худалдан авалтаар 51,549.8 мянган төгрөг, Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр 819.9 мянган төгрөг, 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 1,300.0 мянган төгрөг, эцэг эхчүүдээс хүүхдийн хэрэгцээнд зориулан авсан 6,153.5 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, зарцуулалтаар 59,708.6 мянган төгрөгийн бараа материал буурч, байгууллагын даргын 2020 оны 12-р сарын 28 -ны өдрийн 46 тоот тушаалыг үндэслэн 7,906.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,246,822.6 мянган төгрөг болж 53,538.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 62,394.9 мянган төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь Боловсрол соёлын газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 1,875.9 мянган төгрөгийн төмс арилгагч төхөөрөмж, Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,750.0 мянган төгрөгийн суурин компьютер, БШУЯамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 5,248.5 мянган төгрөгийн зөөврийн компьютероор нэмэгдсэн ба акталсан хөрөнгө бүртгэгдээгүй байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 207.1 мянган төгрөг байсан ба тайлант онд 730,252.8 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, бүх өглөгийг барагдуулж үлдэгдэлгүй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,336,654.2 мянган төгрөг болж 62,211.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 29,481.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан нь ковидтой холбогдуулан хөл хорио тогтоож, цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарлагдаж, нэмэлт санхүүжилт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого*

/мянган төгрөг/

| | 2019.12.31 | 2020.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 51,111.8 | 17,129.8 | (33,982.0) |
| Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих | 497,248.3 | 555,244.0 | 57,995.7 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 35,528.8 | 41,519.5 | 5,990.7 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 59,485.4 | | (59,485.4) |
| **Нийт дүн** | **643,374.3** | **613,893.3** | **(29,481.0)** |

Нийт зардал өмнөх оноос 2,172.26 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал*

/мянган төгрөг/

| | 2019.12.31 | 2020.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 399,551.78 | 441,162.80 | 41,611.02 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,184.08 | 57,643.97 | 11,459.89 |

| | | | |
|---|---|---|---|
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,427.31 | 31,160.05 | (2,267.26) |
| Хангамж, бараа материалын зардал | 28,383.52 | 17,323.06 | (11,060.45) |
| Нормативт зардал | 88,915.59 | 39,889.78 | (49,025.81) |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,391.70 | 1,863.00 | 471.30 |
| Томилолт, зочны зардал | 80.00 | - | (80.00) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 628.00 | 1,030.00 | 402.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 57,914.80 | 64,231.84 | 6,317.04 |
| **Нийт дүн** | **656,476.78** | **654,304.52** | **(2,172.26)** |

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 596,763.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 582,941.6 мянган төгрөг буюу 97.71 хувьтай байгаа нь Ковидтой холбоотой хөл хорионы үеэр цэцэрлэгүүд цахимаар хичээллэсэн тул байр, ашиглалтын зардал багасаж хэмнэлт үүссэнээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд 13,671.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 12 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл байсан байна. 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь цахим системийн алдаанаас шалтгаалж 6 дугаар сард тус цэцэрлэгийн шилэн дансны мэдээллийн жагсаалтанд “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”-ийг оруулах талбар устсантай холбоотой ба шилэн дансны админ эрхэнд хүсэлт илгээж, тусдаа нэвтрэх эрх нээлгэн уг талбарыг нөхөж оруулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж авсан ба биелэлтийг 2020 оны 06-р сарын 22-ны өдрийн 32 тоотоор хариу тайлбар ирүүлэн ажилласан байна.

- Өмнөх тайлант онд авлагыг хянаж, төсвийг зохистой удирдаагүй, авлага барагдуулах үр дүнтэй ажил зохион байгуулаагүйн улмаас 1,295.3 мянган төгрөгийн өглөг, авлагын үлдэгдэлтэй гарсан зөрчил илэрсэн ба 2020 онд авлага өглөгийн үлдэгдэлгүй гарч зөвлөмжийг 100% хэрэгжүүлсэн байна.

- 2019 онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 1,230.4 мянган төгрөгийг цалингийн зардалд бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил илэрснийг залруулж ажилласан байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,315.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,906.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,358.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 50.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 7,906.4 мянган төгрөгийн бараа материал акталж устгасныг орлого үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулга хийсэн.

**Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Нийт албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн манган урамшууллалттай давхцуулан цалингийн зардлын хэмнэлтээс албан хаагч бүрд 106.3 мянган төгрөг, нийт 4,358.3 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн жилд нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийн кодыг зөв бүртгэж буй эсэх дээр анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***Зардлын данстай холбоотой асуудал***

1. ***Илрүүлэлт:*** Хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн ажилтны даатгуулагчийн төрлийн кодыг нийгмийн даатгалд залруулалгүй 06 кодоор буруу тайлагнасан байна.
2. ***Эрсдэл:*** Цалин, нийгмийн даатгалын тооцоо зөрөх, хүүхэд төрүүлсэн эхийн хүүхэд асрах чөлөө дахин 3 жилээр сунахгүй байх.
3. ***Өгсөн зөвлөмж:*** Сангийн сайд, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 211/А112 тоот хамтарсан тушаалын "Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код дараах байдалтай байна" гэж заасны дагуу даатгуулагчийн төрлийн кодчлолыг зөв тооцож тайлагнаж байх.
4. ***Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*** Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 16 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн:

| | | | |
|---|---|---|---|
| Аудитор | [signature] | Б.Пүрэвсүрэн | Огноо |

Анхан шатанд хянасан:

| | | | |
|---|---|---|---|
| Аудитын менежер | [signature] | Б.Эрдэнэ | Огноо |

Хоёр дахь шатанд хянасан:

| | | | |
|---|---|---|---|
| Эрхлэгч, тэргүүлэх аудитор | [signature] | Ц.Нармандах | Огноо |


ОРА-2021/60/СТА-ТШЗ